



“ЛЭНДМН ББСБ” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдэд

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088

Цахим хаяг: www.shonkhor.mn
И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2024 02. 05 № 24/14

танай _____ -ны № _____ -т

АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “ЛЭНДМН ББСБ” ХК -ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн Нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “ЛЭНДМН ББСБ” ХК -ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл олж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус аудитын дүгнэлтийн үргэлжлэл

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланда хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай залтын үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг баримтлан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэх талаар боломжит үндэслэлтэй баталгааг олж авах, түүнчлэн аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй бүхий залилан ба алдааг бүрэн илэрхийлдэг гэсэн баталгаа биш юм.

Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай залтын үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг. АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг.

Бусад

Энэхүү дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн ба дүгнэлтийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)



“ЛЭНДМН ББСБ” ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

**НЭГТГЭСЭН АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

| | | /мян. төгр/ | |
|--|-----------|-------------------|-------------------|
| | Тодруулга | 2022 | 2023 |
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 14 | 20,214,948 | 47,842,587 |
| Хүүний зардал | 14 | (3,949,884) | (9,527,344) |
| Цэвэр хүү болон түүнтэй адилтгах орлого | | 16,265,064 | 38,315,243 |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | 15 | (1,438,655) | (2,684,956) |
| Үнэ цэнийн бууралтын зардлын дараах хүү болон түүнтэй адилтгах орлого | | 14,826,409 | 35,630,287 |
| Удирдлага ө болон үйл ажиллагааны зардал | 16 | (7,656,249) | (10,223,598) |
| Бусад орлого/(зардал), цэвэр | 17 | (637,914) | (35,966) |
| Татварын өмнөх ашиг | | 6,532,246 | 25,370,723 |
| Орлогын албан татварын зардал | 18 | (1,007,265) | (5,574,907) |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | 5,524,981 | 19,795,816 |

төгр төгр

Нэгж хувьцаанд ногдох ашиг

| | | | |
|--|----|------|-------|
| Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг | 21 | 7.47 | 26.78 |
|--|----|------|-------|

SHONKHOR 01
estimate & audit



“ЛЭНДМН ББСБ” ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

/мян.төгр/

| | Тодруулга | 2022 | 2023 |
|---|-----------|-------------------|--------------------|
| ХӨРӨНГӨ | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 4 | 5,217,581 | 7,885,968 |
| Харилцагчдад олгосон зээл | 5 | 69,586,280 | 123,462,373 |
| болов урьдчилгаа | | | |
| Бусад хөрөнгө | 6 | 768,409 | 415,965 |
| Хөрөнгө оруулалт | | 172,230 | - |
| Урьдчилж төлсөн төлбөр | | 45,437 | 55,975 |
| Биет бус хөрөнгө | 7 | 401,095 | 355,542 |
| Үндсэн хөрөнгө | 8 | 373,470 | 306,158 |
| Ашиглах эрх бүхий хөрөнгө | | 217,592 | 945,652 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 20 | 76,663 | 41,318 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | 76,858,757 | 133,468,951 |
| ӨР ТӨЛБӨР | | | |
| Зээл | 9 | 44,225,863 | 77,445,677 |
| Түрээсийн өр төлбөр | 10 | 285,772 | 981,642 |
| Бусад өр төлбөр | 11 | 2,622,414 | 3,863,865 |
| Орлогын албан татварын өглөг | 19 | 815,146 | 3,638,541 |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | | 4,679,661 | 4,798,243 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 20 | - | 9,044 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | | 52,628,856 | 90,737,012 |
| ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | | | |
| Хувьцаат капитал | 12 | 10,756,859 | 10,756,859 |
| Халаасны хувьцаа | 13 | (2,337,547) | (2,337,547) |
| Бусад нөөц | | 57,348 | 57,348 |
| Хуримтлагдсан ашиг | | 15,753,241 | 34,255,279 |
| НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 24,229,901 | 42,731,939 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 76,858,757 | 133,468,951 |



“ЛЭНДМН ББСВ” ХХК БОЛОН ТУУНИЙ ОХИН КОМПАНИ

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

| /мян.төгр/ | | | | | |
|---|---------------------|---------------------|---------------|---------------------------|---------------------------|
| | Хувьцааг капитал | Халаасны хувьцаа | Бусад нөөц | Хуримтлаадсан ашиг | Нийт Эзлийн өмч |
| 2022 оны 01 сарын 01-ний өдрийн байцлаар | 10,756,859 | (2,337,547) | 57,348 | 11,337,213 | 19,813,873 |
| Тайлант жиллийн цэвэр ашиг болон тайлант жиллийн нийт дэлгэрэнгүй орлог Ногдол ашиг | - | - | - | 5,524,981 (1,108,953) | 5,524,981 (1,108,953) |
| 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байцлаар | 10,756,859 | (2,337,547) | 57,348 | 15,753,241 | 24,229,901 |
| Тайлант жиллийн цэвэр ашиг болон тайлант жиллийн нийт дэлгэрэнгүй орлог Ногдол ашиг | - | - | - | 19,795,816 (1,293,778) | 19,795,816 (1,293,778) |
| 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байцлаар | 10,756,859 | (2,337,547) | 57,348 | 34,225,279 | 42,731,939 |



“ЛЭНДМН ББСБ” ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

/мян.төгр/

| | 2022 | 2023 |
|---|---------------------|---------------------|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Татварын өмнөх ашиг | 6,532,246 | 25,370,723 |
| Зээлийн хүүний зардал | 3,716,854 | 8,493,425 |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүний зардал | 152,269 | 940,822 |
| Түрээсийн өглөгт хуримтлуулсан хүү | 80,761 | 93,097 |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын зардал /(буцаалт) | 1,381,057 | 2,699,370 |
| Олгогдохоор батлагдсан зээлийн үүргийн үнэ цэнийн бууралт/(буцаалт) | 57,598 | (14,414) |
| Ашиглах эрх бүхий хөрөнгө болон үндсэн хөрөнгийн элэгдэл | 386,554 | 570,415 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 46,743 | 45,553 |
| Гадаад валютын хамийн өөрчлөлтийн бодит бус алдагдал (ashiig) | 385,521 | (223,852) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | 4,419 | 3,950 |
| Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг | 12,744,022 | 37,979,089 |
| Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд: | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны цэвэр (өсөлт)/бууралт | (38,541,290) | (56,575,463) |
| Бусад хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт | (54,621) | 352,444 |
| Урьдчилж төлсөн төлбөрийн цэвэр (өсөлт)/бууралт | (26,641) | (10,538) |
| Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт) | 1,608,589 | 1,265,774 |
| Үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) мөнгөн гүйлгээ | (24,269,941) | (16,988,694) |
| Орлогын албан татварын төлөлт | (269,808) | (2,704,705) |
| Гуравдагч этгээдийн сүүтгаж авсан албан татвар | (4,062) | (2,418) |
| Түрээсийн өглөгийн хүүний төлөлт | (80,761) | (93,097) |
| Хүүний төлбөр | (3,857,595) | (8,056,575) |
| Үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ | (28,482,167) | (27,845,489) |



**“ЛЭНДМН ББСБ” ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

/мян.төгр/

| | 2022 | 2023 |
|---|-------------------|-------------------|
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ | | |
| Өрийн хэрэгслийн худалдан авалт | (172,230) | - |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | (112,435) | (99,137) |
| Өрийн хэрэгслүүдийн эргэн төлөлт | - | 172,230 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас орсон/(-нд) зарцуулсан мөнгөн гүйлгээ | (284,665) | 73,093 |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Бондын эх үүсвэр | 7,779,662 | 8,705,967 |
| Зээлийн эх үүсвэр | 13,717,978 | 51,398,771 |
| Итгэлцлийн санхүүжилтийн эх үүсвэр | 17,864,887 | 32,054,150 |
| Бондын эргэн төлөлт | (20,000) | (7,500,000) |
| Зээлийн эргэн төлөлт | (4,881,238) | (35,041,154) |
| Итгэлцлийн санхүүжилтийн эргэн төлөлт | (3,974,404) | (17,441,233) |
| Түрээсийн өглөгийн үндсэн төлбөрийн төлөлт | (297,197) | (440,106) |
| Төлсөн ногдол ашиг | (1,108,953) | (1,293,778) |
| Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ | 29,080,735 | 30,442,617 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (буураалт) | 313,903 | 2,670,221 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн зөрүүний нөлөөлөл | - | (1,834) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,903,678 | 5,217,581 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 5,217,581 | 7,885,968 |
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ /хүү/ | | |
| Хүлээн авсан хүү | 20,526,063 | 47,970,615 |
| Хүүний орлого | 20,214,948 | 47,842,587 |
| Мөнгөн бус гүйлгээ: | | |
| Ашиглах эрх бүхий хөрөнгө болон түрээсийн өглөг | 106,318 | 1,188,436 |

